



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XVI.1.2.1 Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын их засвар /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээний Гэмтэл согог судлалын үндэсний төв /ГССҮТ/-ийн хаалганы засварын 10.000.000 / Арван сая / төгрөг, ГССҮТ-ийн хүлээн авах яаралтай тусламжийн байрны засварын 62.000.000 /Жаран хоёр сая / төгрөгийн гэрээ байгуулах, гэрээ сунгах, цуцлах, хяналт тавих, санхүүжүүлэх эрхийг Гэмтэл согог судлалын үндэсний төвийн дарга /Б.Бат-Оргил/-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтэс /Г.Баярсайхан/-т даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080152